



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/296

Булган сум

“Шинжлэх ухаан, технологи, инновацыг  
орон нутагт нутагшуулъя” аяныг зохион байгуулах  
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Инновацын тухай хуулийн 11 дүгээр зүйл, Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Булган аймгийн Засаг даргын хооронд байгуулсан 2024 оны хамтран ажиллах гэрээний 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинжлэх ухаан, технологи, инновацын ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, орон нутагт тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанд тулгуурлан шийдвэрлэх, мэдээллийн технологийн боломжийг таниулах, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор зохион байгуулж буй “Шинжлэх ухаан, технологи, инновацыг орон нутагт нутагшуулъя” аяныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн дарга)

Ж.Ганболд (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний  
газрын дарга)

А.Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
дарга)

П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)

Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)

Ж.Орхонтуул (Боловсрол, шинжлэх ухааны газрын  
инновацын асуудал хариуцсан мэргэжилтэн)

О.Ууганчимэг (Хөгжимт, жүжгийн театрын дарга)

Н.Пүрэвсайхан (ХААИС-н харьяа Булган аймаг дахь  
Политехник коллежийн захирал)

Нарийн бичгийн дарга: А.Оюунжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

2. “Шинжлэх ухаан, технологи, инновацыг орон нутагт нутагшуулъя” аяныг зохион байгуулах талаар удирдлага, зохион байгуулалтыг шуурхай арга хэмжээ авч, ажлын хэсгийн гишүүдийг үүрэгжүүлэн, арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ